



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 274

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 11 нэрийн нийт 72,964,491.66 (далан хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун ерэн нэгэн төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 20,118,620.00 (хорин сая нэг зуун арван найман мянга зургаан зуун хорин) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн нэгжийн зохицуулагч Ж.Түвшинсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 08 дугаар сарын 08-ны/ний өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

"ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ" ТӨСЛИЙН НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦАА ҮНИЙГ ШИНЭЭЧЛЭН
ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Нэр төрөл	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
	Тээврийн хэрэгсэл							
1	Жийп автомашин Land Cruiser 78 JTEEB71J3070J9018 Улсын дугаар УНС 23-54	2010.05.13	1	47,382,136.31	47,382,136.31	5	15,000,000.00	15,000,000.00
	Компьютер, техник хэрэгсэл							
2	Хувилагч, хэвлэгч, сканнер Canon iR2520	2016.06.01	1	4,341,457.62	4,341,457.62	1	868,300.00	868,300.00
3	Сүлжээний толгой компьютер (Сервер компьютер Dell PowerEdge R320)	2016.06.01	1	3,867,314.46	3,867,314.46	2	773,500.00	773,500.00
4	Суурин компьютер (иж бүрэн) Dell Optiplex 9020MT, Dell U2412M/24" Ultrasharp IPS LED display	2016.06.01	1	2,162,180.36	2,162,180.36	2	434,500.00	434,500.00
5	Суурин компьютер (иж бүрэн) Dell Optiplex 3020MT, Dell U2412M/24" Ultrasharp IPS LED display	2016.06.01	6	1,716,853.23	10,301,119.38	2	343,370.00	2,060,220.00
6	Хэвлэгч өнгөт лазер принтер HP LaserJet Pro M451dn	2016.06.01	1	1,248,087.85	1,248,087.85	2	249,600.00	249,600.00
7	Хэвлэгч лазер хар Принтер HP P2055D	2009.11.01	1	599,900.00	599,900.00	2	120,000.00	120,000.00
8	Дүрс гаргагч Проектор Acer X1130P DLP Projector	2010.04.08	1	1,638,312.00	1,638,312.00	2	327,600.00	327,600.00
9	Суурин утасны сүлжээний аппарат Panasonic ATC KX-TES824	2009.11.11	1	1,086,464.32	1,086,464.32	2	217,300.00	217,300.00
10	Суурин утасны аппарат Panasonic KX-T7730	2009.11.11	1	161,799.96	161,799.96	1	32,400.00	32,400.00
11	Суурин утасны аппарат Panasonic KX-TSC11MXW	2009.11.11	4	43,929.85	175,719.40	1	8,800.00	35,200.00
			19		72,964,491.66 (далан хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун ерэн нэгэн төгрөг жаран зургаан мөнгө)		18,375,370.00	20,118,620.00
	Нийт дүн							(хорин сая нэг зуун арван найман мянга зургаан зуун хорин)